

ӨГҮҮЛЭЛ

ОХУ-ын 2023 оны гадаад бодлогын шинэ үзэл баримтлалд хийсэн судалгаа**Адъяагийн Нямдолжин**^{ID}

Доктор (Ph.D)

Шинжлэх Ухааны Академийн Олон улс судлалын хүрээлэн

Улаанбаатар, Монгол Улс

nyamdoljin@mas.ac.mn

Хураангуй: Тус өгүүлэлд ОХУ-ын 2023 онд батлагдсан Гадаад бодлогын шинэ үзэл баримтлалын онцлогийг өмнөх 1993, 2000, 2008, 2013, 2016 оны үзэл баримтлалуудтай харьцуулах, шинээр дэвшүүлсэн үзэл, санаа, чиг хандлагийг Орос-Украины дайны нөхцөл байдлын хүрээнд судлахыг зорьсон болно. Түүнчлэн ОХУ-ын зүгээс Монгол Улсын талаар баримтлах бодлогыг тус шинэ үзэл баримтлалын зүйл заалттай уялдуулан авч үзэхэд Монгол Улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэлийн нэг болох ОХУ-Монгол Улсын харилцаанд учрах сорилтуудыг урьдчилан харах, судлан шинжлэх зайлиггүй шаардлага тулгарч байна.

Түлхүүр үгс: ОХУ, 2023 оны гадаад бодлогын үзэл баримтлал, Орос-Украин, геополитик

Аливаа улс орны гадаад бодлогын үзэл баримтлал нь Засгийн газрын гадаад бодлогын тулгуур баримт бичиг болохын хувьд олон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулах, гадаад бодлогын шийдвэр гаргаж хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө, өөрөөр хэлбэл тухайн улсын зүгээс бусад улстай харилцах харилцаа, тодорхой хугацаанд үйл ажиллагааг чиглүүлэх ерөнхий зорилтуудыг

тусгадаг эрх зүйн баримт бичиг хэдий ч зайлшгүй дагаж мөрдөх хууль дүрэм биш юм. Энэ ч утгаараа Оросын Гадаад бодлогын үзэл баримтлал нь Орос улс ямар гадаад бодлого хэрэгжүүлж, мөрдлөг болгохоо биш, харин дэлхий нийтэд гадаад бодлогын чиглэл, зорилго, зорилт, хандлагаа тодотгон таниулахыг зорьдог, гадаад бодлогын үйл ажиллагааны агуулга, зарчим,



үндсэн чиглэлийн талаархи үзэл бодол, төсөөллийг тусгадаг баримт бичиг юм.

Шинэ үзэл баримтлал батлах геополитикийн нөхцөл шаардлага

ОХУ-ын Үндсэн хуулийн 80-р зүйлд зааснаар¹ Үндсэн хууль, холбооны хуулийн дагуу тус улсын гадаад бодлогын үндсэн чиглэлийг ОХУ-ын Ерөнхийлөгч тодорхойлдог бөгөөд тэрээр дотоод болон олон улсын харилцаанд ОХУ-ыг төлөөлдөг. ОХУ ерөнхийлөгчийн засаглалтай, шаардлагатай тохиолдолд ерөнхийлөгч Төрийн Думыг тараах онцгой эрх эдэлдэг. Үндсэн хуулийн 84-р зүйлд “ОХУ-ын Ерөнхийлөгч Холбооны хуралд улс орны нөхцөл байдал, улсын дотоод, гадаад бодлогын үндсэн чиглэлийн талаар жил бүр илгээлт тавина”² гэж заасны дагуу 1994 оноос хойш ОХУ-ын Ерөнхийлөгчийн жил бүр Холбооны хуралд тавьдаг илгээлт нь Оросын тухайн жилийн гадаад, дотоод бодлогын ололт амжилтыг дүгнэх, цаашдын бодлого төлөвлөгөөг танилцуулах нэг чухал үйл явдал төдийгүй Оросын баримталж буй байр суурь, явуулж буй гадаад бодлого эндээс харагдаж байдаг. ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путины 2023 оны илгээлт ОХУ-ын зүгээс Украинд зарласан “цэргийн тусгай ажиллагаа”-ны өмнөх өдөр буюу 2023 оны 2 дугаар сарын 21-нд болсноороо онцлогтой байв. В.В.Путин Холбооны хуралд тавьсан илгээлтдээ, дэлхий дахинд эргэлт буцалтгүй эрс өөрчлөлт гарч, улс орон, ард түмнийхээ ирээдүйг тодорхойлох түүхэн чухал

цаг үе ирээд байгааг онцлоод, 2014 оны төрийн эргэлтийн дараа Украинд бий болсон неонацист дэглэмээс үүдэлтэй аюул заналхийллийг арилгах, түүхэн газар нутаг дээрээ ард иргэдээ хамгаалах, эх орныхоо аюулгүй байдлыг хангах зорилгоор жилийн өмнө цэргийн тусгай ажиллагаа явуулах шийдвэр гарсан талаар мэдэгдэв.³ Түүнчлэн тэрээр “АНУ, НАТО-гийн цэргийн бааз, биологийн нууц лабораториудаа Оросын хилийн ойролцоо түргэн шуурхай байрлуулж, Киевийн дэглэмийг хяналтандаа байлгаж, хилийн ойролцоо цэрэг, улс төрийн тогтворгүй байдалд хүргэж, Украиныг томоохон дайнд бэлтгэж байна”⁴ хэмээн илгээлтдээ дурдсан байна.

Орос-Украины дайны дараа 2022 оны 10-р сард Валдай хэлэлцүүлгийн клубээс зохион байгуулдаг олон улсын хурал дээр ерөнхийлөгч В.В.Путин “Дэлхийн соёл иргэншлийн үндсийг “Дорно дахин, Латин Америк, Африк, Евразийн уламжлалт нийгэм” бүрдүүлдэг. Харин “Өрнөдийн өөрсдийнх нь хүч чадавх үгүй болохын хирээр, бусад соёл иргэншлийн чөлөөтэй хөгжих нөхцөлийг хааж, боох, хязгаарлахыг хичээж байна” хэмээн тэмдэглэн хэлсэн.

Чингэхдээ, Украиныг тойрсон геополитикийн хямрал 2014 оноос ч өмнө буюу 2008 оны дөрөвдүгээр сард

¹ Конституция Российской Федерации. <http://www.constitution.ru/10003000/10003000-6.htm> . Статья 80-4.

² Конституция Российской Федерации. <http://www.constitution.ru/10003000/10003000-6.htm> . Статья 84-ё

³ Послание Президента Федеральному Собранию. <http://kremlin.ru/events/president/news/70565>

⁴ Мөн тэнд

болсон НАТО-гийн Бухарестийн дээд хэмжээний уулзалтын үеэр АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Буш Украин, Гүрж хоёрыг “НАТО-ийн гишүүн болохыг” дэмжих ёстой хэмээн мэдэгдсэнээр⁵ эхэлсэн юм. Хэдийгээр эдгээр улсууд НАТО-д элсэх урилга аваагүй боловч Оросын талын дургүйцлийг өдөөсөн бөгөөд ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин “Хэрэв Украин НАТО-д элсэх юм бол Украин нэгдмэл улсын хувиар оршин тогтнох эсэх тухай асуудал яригдах бөгөөд Крым болон Зүүн бүс нутгуудыг булаан авах болно. Мөн Абхаз, Өмнөд Осетийг Орос хүлээн зөвшөөрч, Гүрж (эвслийн гишүүн) болон Оросын хооронд “буфер бүс” бий болгоно.”⁶ хэмээн анхааруулсан.

Улмаар 2008 оны 8-р сарын Өмнөд Осетийг тойрсон үйл явдал буюу Орос, Гүржийн хоорондох “таван өдрийн дайн”-аар хуучин Зөвлөлтийн нутаг дэвсгэр дээрх Орос, НАТО-ын ашиг сонирхол хийгээд байр сууриа илэрхийлэх шинэ, ноцтой зөрчлийг гаргаж ирсэн юм. Нөгөөтээгүүр,

НАТО-гийн тэлэлт, цаашлаад Украиныг Барууны орнуудад нэгтгэх гэсэн оролдлогоос үүдэлтэй хямрал нь Оросын эзэнт гүрний амбиц гэхээс илүүтэй Оросын оршин тогтнох аюулгүй байдалтай холбоотой асуудал юм.

Чухамхүү АНУ ба Барууны орнуудын бодлого, үйл ажиллагаа болон дээр дурдсан геополитикийн хүчин зүйлсийн нөлөөгөөр 2008, 2013, 2016 оны гадаад бодлогын үзэл баримтлалаа шинэчлэн баталж байсан бол энэ удаа 2022 оны 2 дугаар сарын 22-нд Украины эсрэг “цэргийн тусгай ажиллагаа” эхлүүлсний дараа ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдөр “ОХУ-ын гадаад бодлогын үзэл баримтлал”-ын шинэчилсэн төслийг батлах тухай зарлигт гарын үсэг зурж, Оросын гадаад бодлогын үндэсний ашиг сонирхол, үндсэн зарчим, стратегийн төлөвлөгөө, зорилт, тэргүүлэх чиглэл зэргийг тодорхойлсон юм.

Залгамж чанар ба шинэлэг тал

2023 оны үзэл баримтлал нь 2022 оны 2 дугаар сард Украинд “цэргийн тусгай ажиллагаа” зарласны дараах анхны албан ёсны баримт бичиг болохын сацуу Оросын дипломат үйл ажиллагааг үзэл суртлын хийгээд цэрэг дайны хэрэгслээр хэрэгжүүлэх үзэл санаа агуулсан гэдгээрээ ихээхэн анхаарал татаж байна. ОХУ-ын 2023

оны гадаад бодлогын үзэл баримтлал нь 1993 онд анхны үзэл баримтлал гарснаас хойш гарсан 2000, 2008, 2013, 2016 оны үзэл баримтлалууд дахь залгамж чанар болоод шинэлэг талууд тусгагдсан Оросын гадаад бодлогын үзэл санааны хувьсал өөрчлөлтийг нэгтгэн харуулсан баримт бичиг гэж үзэж болно. Чингэхдээ 1993, 2000, 2008, 2013 оны

⁵ President Bush Visits Bucharest, Romania, Discusses NATO. <https://georgewbush-whitehouse.archives.gov/news/releases/2008/04/20080402-2.html>

⁶ Путин пригрозил аннексировать Крым и Восточную Украину в случае принятия Украины в НАТО. <https://www.newsru.com/russia/07apr2008/annex.html>. 07.04.2008

үзэл баримтлалын дөрвөн хувилбар нь ОХУ-ын төрийн тэргүүнүүдийн (Б.Н.Ельцин, В.В.Путин, Д.А.Медведев, дахин В.В.Путин) засгийн эрхэнд шинээр гарсан үеүдтэй давхцаж байдаг нь нэг талаас ерөнхийлөгчдийн мөрийн хөтөлбөр мэт сэтгэгдэл төрүүлж байдгийг хэлэх нь зүйтэй болов уу.

1991 онд ЗСБНХУ задран унасны дараа Оросын гадаад бодлогын үндэс нь хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан Бүгд Найрамдах улсууд болон гадаад улс орнуудтай шинэ харилцаа тогтоох, олон улсын харилцааны тогтолцоонд нэгдэх явдал байв. 1993 оны 4 дүгээр сарын 23-нд ОХУ-ын Ерөнхийлөгч Борис Ельцины зарлигаар “ОХУ-ын гадаад бодлогын үзэл баримтлалын ерөнхий байдал” нэртэйгээр үзэл баримтлалаа баталсан. Баримт бичигт тусгагдсан гадаад бодлогын хамгийн чухал зорилтууд нь төрийн эв нэгдэл, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хадгалах, зэвсэгт мөргөлдөөнийг зогсоох, улс орны эргэн тойрон дахь мөргөлдөөнийг шийдвэрлэх, “дэлхийн нөлөөллийн тэнцвэрт байдалд Оросын гүйцэтгэх үүргийг” хэвээр хадгалах, гадаад бодлогын тэргүүлэх чиглэлээ тодорхойлох явдал байв. Энэ үүднээс анхны гадаад бодлогын үзэл баримтлалын гол зорилго нь ОХУ-ын “их гүрний” байр суурийг хадгалж үлдэх, ТУХН-ийн орнуудад оршин сууж байгаа орос үндэстэн болон орос хэлээр ярьдаг хүн амын хүний эрхийг, ялангуяа угсаатны эрхийг чанд сахихыг баталгаажуулсан. Баримт бичигт мөн

Оросын гадаад бодлогын чиг баримжаа нь үзэл суртлын зарчимд тулгуурлах бус, харин “үндэсний ашиг сонирхолд” тулгуурлах ёстойг онцолсон байна. Хөрш зэргэлдээ улсууд, түүнчлэн “эдийн засаг, технологийн хувьд хүчирхэг, хөгжингүй” Барууны орнууд, “бүс нутгийн шинэ үйлдвэржсэн орнууд” гэсэн гурван бүлэг оронтой тусгай харилцаа тогтоох бодлогыг тунхагласан. Олон улсын аюулгүй байдлын салбарт зэвсгийг хязгаарлах, зэвсэг хураах чиглэлийг дэмжих, дэлхийн тэргүүлэх гүрнүүд болон Барууны батлан хамгаалахын бүтэцтэй хамтран ажиллах зорилт тавьсан. Өөр нэг нэн тэргүүний зорилго бол “Стратегийн түншлэл, цаашдаа эвслийн харилцаанд анхаарлаа хандуулан АНУ-тай харилцаагаа тогтвортой хөгжүүлэх”-ийг⁷ тусгасан байдаг.

ОХУ-ын 2000 оны Гадаад бодлогын шинэ үзэл баримтлал нь ОХУ-ын өмнөх ерөнхийлөгч Б.Н.Ельцины гадаад бодлогоос В.Путины гадаад бодлогод шилжих эхлэлийг тавьсан баримт бичиг болсноороо онцлог байв. Орос Улс их гүрэн болохын хувьд тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдал, улс орны аюулгүй байдлыг хангах, түүнийг хөгжүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлэхээс гадна олон улсын харилцааны олон туйлт тогтолцоог бүрдүүлэх, олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээнд суурилсан тогтвортой, шударга, ардчилсан дэлхийн дэг журмыг бий болгох явдал

⁷ Основные положения Концепции внешней политики Российской Федерации утверждены Распоряжением Президента Российской Федерации Б.Н.Ельцина от 23 апреля 1993 г. // Концепции внешней политики РФ 1993-2023 гг. тексты документов. Б.м.: Б.изд., 2023. стр.6 https://library/downloadelibrary_50481108_99282815.pdf.

үндсэн зорилтуудын нэг байв. Түүнчлэн “Оросын хилийн дагуу сайн хөршийн бүс” байгуулах, ОХУ-ын иргэд, хилийн чанад дахь эх орон нэгтнүүдийн эрх ашгийг хамгаалах, Орос Улсын талаарх эерэг ойлголтыг дэлхий нийтэд түгээн дэлгэрүүлэх, орос хэл, соёлыг сурталчлах талаар тусгасан.⁸

ОХУ-ын гадаад бодлогын тэргүүлэх чиглэлд ТУХН (Тусгаар Улсуудын Хамтын нөхөрлөлийн орнууд), Европын Холбоо, АНУ, БНХАУ, Энэтхэг, Япон, Африк, Ойрх Дорнод, Төв ба Өмнөд Америк гэх мэт эрэмбэлэн бүс нутгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлохдоо ОХУ нь дэлхийн гол төвүүд, тэдгээрийн оролцогчдын Оростой хоёр талын харилцаа холбоог өргөжүүлэх хэр хэмжээг харгалзан үзэхээ илэрхийлсэн байна.

2000-аад оны В.Путины гадаад бодлого АНУ, ЕХ-той өргөн хүрээтэй, нягт харилцаа тогтоохыг эрмэлзэж байв. 1993 болон 2000 оны үзэл баримтлалд Оросыг “их гүрэн” гэж тодорхойлж байсан нь ЗХУ задарсаны дараа ОХУ олон улсад эзлэх байр сууриа алдаагүй, Зөвлөлтийн үеийн их гүрний байр сууриа хадгалж үлдсэн гэдгийг олон улсад харуулах, дэлхийн хамтын нийгэмлэгт хүлээн зөвшөөрөгдөхөд оршиж байв.

ОХУ-ын Ерөнхийлөгчөөр сонгогдсон Дмитрий Медведевын 2008 оны ОХУ-ын гадаад бодлогын шинэ үзэл баримтлалд олон туйлт ертөнцийг бэхжүүлэх, хүчний төвүүдтэй хамтын ажиллагаагаа эрчимжүүлэх, чингэхдээ “түүхэн өрнөдийн орнууд даяаршлын үйл явцад монополь байдлаа алдахын

хэрээр Оросыг “тогтоон барих” бодлогоо эрчимжүүлж байна” гэж үзсэн. Өмнөх хоёр үзэл баримтлалд ОХУ-ыг “их гүрэн” хэмээн нэрлэж байсан бол шинэ баримт бичигт анх удаа “Евразийн их гүрэн” хэмээн тодорхойлсон байна. Түүнчлэн Евразийн Эдийн засгийн Нийгэмлэгийн хүрээнд Гаалийн холбоо байгуулах замаар Беларусь, Казахстантай хамтын ажиллагаагаа идэвхжүүлнэ гэсэн бол “Орос, Беларусийн холбоог” бэхжүүлэх тухай заалт хасагдсан байна.

2013 оны ОХУ-ын Гадаад бодлогын үзэл баримтлалын баримт бичгийн үндсэн заалтуудад өмнөх баримт бичгүүдтэй харьцуулахад дорвитой өөрчлөлт ороогүй байна. Энэхүү үзэл баримтлалд анх удаа “Зөөлөн хүч” гэдэг нь “сонгодог дипломат ёсыг орлох иргэний нийгэм, мэдээлэл, харилцаа холбоо, хүмүүнлэгийн болон бусад арга, технологид суурилсан гадаад бодлогын асуудлыг шийдвэрлэх цогц арга хэрэгсэл” гэж тодорхойлсон.

Оросын гадаад болон дотоод орчины өөрчлөлтийг дагаад хэд хэдэн тодотгол, нэмэлт шинэтгэл хийсэн 2016 оны гадаад бодлогын үзэл баримтлалд анх удаа Сири болон “Исламын улс” бүлэглэлийн тухай зүйл орсон бол Украин тэргүүлэх чиглэлээс хасагдсаны зэрэгцээ “АНУ-ын өдөөн хатгалагт” хатуу хариу өгөхөө амласан байна. Үүнээс харахад уг баримт бичгийн гол өөрчлөлт нь ирээдүйд тус улсыг дэлхий дахинаас тусгаарлагдах эрсдэл гарахаас сэргийлэх, дэлхийн болон бүс нутгийн олон улсын харилцааны

⁸ Концепция внешней политики Российской Федерации от 28 июня 2000 года. // Концепции Внешней политики РФ. 1993-2023 гг. тексты документов. Б.м.: Бизд., 2023. стр.34. https://library/download/elibrary_50481108_99282815.pdf,

динамик өөрчлөлт, түүнд Оросын эзлэх байр суурийг тодотгох, улс хоорондын олон улсын хэмжээний зөрчил, түүнийг зохицуулахад гүйцэтгэх үүргээ нэмэгдүүлэх, Оросын гадаад бодлогод нөлөөлж байгаа хүчин зүйлсийг эргэж харах, үнэлж дүгнэх, мөн идэвхитэй гадаад бодлого явуулахад чиглэгдэж байв.

2013 оны өмнөх үзэл баримтлалтай харьцуулахад, шинэ үзэл баримтлалд Украины асуудалтай холбогдон Оросын эсрэг авсан хориг арга хэмжээнээс үүдэн нийгэм эдийн засагт сөргөөр нөлөөлж буй байдалд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр дэлхийн эдийн засгийн харилцаанд Оросын байр суурийг бэхжүүлэх, түүний бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, хөрөнгө оруулалтыг ялгаварлан гадуурхах, олон улсын болон бүс нутгийн эдийн засаг, санхүүгийн байгууллагуудын боломжийг энэ зорилгод ашиглах явдлыг гаргуулахгүй байхыг заасан байна.

Түүнээс гадна, өмнөх үзэл баримтлалд орчин үеийн олон улсын харилцааг глобаль санхүү, эдийн засгийн хямралаар тодорхойлж байсан бол шинэ хувилбарт “олон төвт” олон улсын харилцааны тогтолцоо бүрэлдэн тогтох явцын гүнзгий өөрчлөлтийн үеийг туулж байгаа талаар дурджээ.

Энэ нь Орос Улс ашиг сонирхлоо дэлхийн хэмжээнд тодорхойлж байдаг улсын хувьд дэлхийн шинэ дэг журам бий болж байгаа талаар тодорхой тусгаснаараа онцлог байв.

Түүнчлэн үзэл баримтлалд нэмэлт өөрчлөлт орсны зэрэгцээ хасагдсан зарим зүйлүүдийг дурдвал, ОХУ Испанийн вант улстай хоёр талын харилцан ашигтай харилцааг хөгжүүлнэ гэсэн бол Голланд болон Их Британи зэрэг орнуудыг “бусад улсууд” гэсэн заалтанд багтааж тусгайлан авч үзээгүй байна. Түүнчлэн Зүүн Өмнөд Европ, Балканы бүс нутгийн орнууд үзэл баримтлалын зүйл заалтаас хасагдсан ажээ.

Ази Номхон далайн бүс нутгийн орнуудтай харилцах харилцаанд улс орнуудын дэс дараалалд өөрчлөлт орсон бөгөөд өмнөх үзэл баримтлалд БНХАУ, Энэтхэг, БНСУ, Япон, Монгол Улс гэсэн дэс дараалалтай байсан бол шинэ үзэл баримтлалд БНХАУ, Энэтхэг, Монгол Улс, БНСУ, Япон гэсэн дэс дараалалаар өөрчлөлт орсон байна

Гадаад бодлогын хувьд Хятадтай харилцах харилцааг онцлон хамтын ажиллагааны жишиг хэмээн тодорхойлсон нь экспортлогч орноо сонгох боломж тун бага байгаа нөхцөлд зах зээл нь хумигдах эрсдэлээс сэргийлэх нэг гарц гэж харсан байна.

2023 оны үзэл баримтлалын түрэмгий, үзэл сурталжсан, суртал ухуулгын шинж чанар

Нэгдүгээрт, 2023 оны “Гадаад бодлогын үзэл баримтлал”-ын ерөнхий төсөөлөл бол хэт түрэмгий, үзэл сурталжсан, суртал ухуулгын шинж

чанарыг агуулж байна гэж хэлж болохоор байна. Тухайлбал, Оросын ертөнц, барууны ноёрхол, неоколониализм, нэгдмэл Баруун, уламжлалт үнэт зүйлс,

олон туйлт ертөнц, англо-саксон, русофоби буюу оросоос айх, неонацизм зэрэг үгнүүдийг дурдаж болно. Орос Улс Украин руу хийсэн түрэмгийллээ зөвтгөх үүднээс эдгээр нэр томъёог тогтмол ашиглах болсон бөгөөд энэ удаад Оросын албан ёсны баримт бичигт кодлогдсон нь анхаарал татаж байна.

Хоёрдугаарт, шинэ үзэл баримтлалд: “Орос бол Орос ертөнцийн (Русский мир) соёл иргэншлийн нийтлэг байдлыг бүрдүүлдэг Оросын ард түмэн ба бусад ард түмнийг нэгтгэсэн Еврази ба Евро-Номхон далайн өргөн уудам их гүрэн болох өвөрмөц соёл иргэншил юм”⁹ хэмээн анх удаагаа тодорхойлсон байна. Чингэхдээ Орос Улс өөрийгөө Европ, Азиас тусдаа бие даасан соёл иргэншил гэж тодорхойлохыг эрмэлзээд зогсохгүй олон улсын дэг журмын өнцгөөс тайлбарлаж, өөрчлөн зохион байгуулах зорилгоо онцлон тэмдэглэсэн байна.

2023 оны Гадаад бодлогын шинэ үзэл баримтлалд 2016 оны үзэл баримтлалд тусгагдаагүй нэг зүйл бол үзэл баримтлалын агуулгын ихэнх хэсэг нь бүс нутаг, муж улсуудын талаарх бодлогыг тусгасан явдал юм. Энэ нь дэлхийг өөр өөр бүс нутаг, тив, улсаар нь ангилж, улмаар бүс нутаг бүрт чиглэсэн Оросын бодлогыг нарийвчлан, улмаар ОХУ-ын гадаад бодлогын тэргүүлэх чиглэлд тулгуурлан бүс нутгийн байгууллага, улс орнуудын талаарх байр суурь, бодлогоо тодорхойлсон байна. Жишээлбэл, “Ойрх хилийн чанад” (ближнее зарубежье), Арктик,

Еврази тивд Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улсыг хамруулан, Ази Номхон далайн бүс нутаг, Лалын ертөнц, Африк, Латин Америк ба Карибын тэнгис, Европын бүс, АНУ ба бусад, Англо-Саксоны орнууд, Антарктид хэмээн ангилжээ. Ийнхүү 2023 оны үзэл баримтлал өмнөх хувилбаруудтай харьцуулахад нэлээд өөрчлөгдсөн нь харагдаж байна.

Товч дүгнэхэд дараах зүйлийг онцолж болохоор байна. Үүнд: дэлхийг есөн бүс болгон ангилах; хуучин ЗХУ-ын харьяанд байсан орнуудыг дүрсэлж байсан “ойрх хилийн чанад” хэмээх томъёолол үзэл баримтлалд дахин гарч ирсэн; Евразийн эх газрын хамт Хятад, Энэтхэгийн тухай тодорхой дурдсан; Ази, Номхон далайн бүс нутгийг АСЕАН-ы улс орнуудаар хязгаарласан; Исламын ертөнцийн талаарх бүс нутгийн түгээмэл бүс нэр томъёо хэрэглэсэн; АНУ, Их Британи, Австрали, Канад зэрэг улсуудыг Англо-Саксоны муж гэж нэрлэсний зэрэгцээ үзэл баримтлалын төгсгөл хэсэгт оруулсан нь Оросын хувьд эдгээр улсуудын дипломат харилцааны тэргүүлэх ач холбогдол буурсныг илтгэж байна. Гадаад бодлогын үзэл баримтлалын өмнөх хувилбаруудад Ази, Номхон далайн орнуудад хандахдаа Хойд болон Өмнөд Солонгос, түүнчлэн Японд чиглэсэн нарийвчилсан бодлогыг тусгасан бол 2023 оны үзэл баримтлалд Солонгосын хойгийн тухай дурдаагүй байна.

Чингэхдээ БНАСАУ-ын цөмийн асуудал, Солонгосын хойгийн нөхцөл

⁹ Концепция внешней политики Российской Федерации от 31 марта 2023 года. // Концепции внешней политики РФ 1993-2023 гг. тексты документов. Б.м.: Б.изд., 2023. стр.98 https://library/download/elibrary_50481108_99282815.pdf.

байдал, Өмнөд болон Хойд Солонгостой тэнцвэртэй хамтран ажиллах шаардлагатай зэрэг асуудлыг хөндсөн “Гадаад бодлогын үзэл баримтлал”-ын өмнөх хувилбаруудаас ялгаатай нь Солонгосын хойгийн асуудал шинэ үзэл баримтлалаас бүрмөсөн хасагджээ. Энэ нь сүүлийн үед олны анхааралд өртөөд байгаа Хойд Солонгос-Оросын харилцаа төдийлөн ойр биш байгааг харуулж байна. Орос Улс Өмнөд Солонгосыг Оростой дайсагнагч “хамтын Барууны” бүлэгт багтааж, харин ОХУ-ын хамтран ажиллахыг зорьж буй “Дэлхийн өмнөд хэсэгт” Хойд Солонгос багтаж байгаа хэмээн үзэх нь зөв байх. Хойд Солонгос бол Зүүн хойд Ази болон Солонгосын хойгийн эргэн тойронд АНУ-ын эсрэг өрсөлдөж буй Орос-Хятадын эвсэлд нэгдсэнээр Хүйтэн дайны шинэ блоккийн нэгдэл хурдасч, үүний үр дүнд Өмнөд Солонгосын аюулгүй байдлын орчин улам дордох нь дамжиггүй.

Өмнөд Солонгос ОХУ-ын эсрэг хориг арга хэмжээнд оролцож, Орос

Өмнөд Солонгосыг найрсаг бус улс хэмээн тодорхойлсон тул Өмнөд Солонгос, ОХУ-ын засгийн газрууд харилцаагаа өмнөх түвшинд нь сэргээх явдал тийм ч амар биш байх болно.

Гэхдээ Орос бол Солонгосын хойгтой газарзүйн хувьд ойр оршдог тул Хойд Солонгосын цөмийн асуудлыг шийдвэрлэх, Зүүн Хойд Азийн энх тайван орчныг бүрдүүлэхийн тулд зөвлөлдөж, хамтран ажиллах шаардлагатай чухал түнш юм. Өмнөд Солонгосын засгийн газрын хувьд Хойд Солонгос-Хятад-Оросын эвслийг бодитой болгохгүйн тулд дипломат хүчин чармайлт гаргах хэрэгтэй болох нь харагдаж байна.

Эндээс харахад Оросын дэлхийн талаарх ойлголт өөрчлөгдсөний сацуу Путины засаглалын үед Орос улсад үндсэрхэг үзэл, оросын соёл иргэншил, орос төвт үзэл, эх оронч үзлийг онцолсон нийгмийн уур амьсгал эрчимжсэнийг илэрхийлж байна.

АНУ болон Барууны орнуудын эсрэг Даяар Өмнөдтэй хамтрана

2023 оны Гадаад бодлогын үзэл баримтлалаар дамжуулан ОХУ Барууны орнууд, тэр дундаа АНУ-ын эсрэг байр сууриа хадгалж, Барууны бус улс орнуудтай хамтын ажиллагаагаа бэхжүүлэхэд анхаарч ажиллахаа мэдэгдэв. Оросын Барууны орнуудад үл итгэх байдал, заналхийллийн талаарх ойлголт 2016 оны гадаад бодлогод туссан байдаг ч энэ удаагийн үзэл баримтлалд Барууны орнууд руу чиглэсэн хандлага нэлээд хатуу өнгө аястай болсон. Барууны орнуудын тэргүүлсэн

даяаршлыг Орос Улс империализм, колоницлол хэмээн тодорхойлж, дэлхий дахинд “хорлон сүйтгэгч неолиберал үзэл суртлын хандлагыг” эсэргүүцэх болно гэдгээ илэрхийлжээ. Цаашилбал, 2023 оны үзэл баримтлалд Оросыг тогтоон барих, тусгаарлах Барууны зорилго, үзэл санааг шүүмжлэн, АНУ-ыг Барууны орнуудын хамтаар Оросын эсрэг “түрэмгий бодлогын гол өдөөгч, зохион байгуулагч, гүйцэтгэгч” хэмээн тодорхойлсон байна.

Түүнчлэн Ази, Африкийн орнууд

хөгжихийн хэрээр дэлхий дахин “олон туйлт ертөнц” рүү шилжиж байгаа энэ үед Барууны орнууд, тэр дундаа АНУ энэхүү олон туйлт үзэл баримтлалаас татгалзсанаар дэлхий дахинд “сүйтгэх нөлөө” үзүүлж, одоо байгаа дэг журмыг хадгалахыг эрмэлзэж байна хэмээн тэмдэглэсэн байна. Энэ үүднээс Орос улс Барууны ноёрхлыг эсэргүүцэгч гол улсын хувьд Оросыг сулруулах бодлого хэрэгжүүлэн, Украиныг Барууны хяналтанд байлгах гэсэн оролдлого нь эдгээр хүчин чармайлтын нэг хэсэг хэмээн үзжээ. Цаашлаад үзэл баримтлалд, АНУ болоод Барууны орнуудын хуйвалдааны улмаас Оросыг Украины дайнд татан оруулахад хүргэсэн хэмээн буруутган, энэ бол ОХУ-ын сонголт биш байсан хэмээн дурджээ.

Оросын эсрэг Барууны хориг арга хэмжээнд нэгдээгүй орнууд болох Хятад, Энэтхэг, Исламын ертөнц, Африк, Латин Америк, Карибын тэнгис, Зүүн өмнөд Азийн орнуудтай харилцаагаа бэхжүүлнэ гэдгээ мэдэгдэж, өөрөөр хэлбэл, Орос улс Даяар Өмнөд (Global South) хэмээн нэрлэгддэг улс орнуудтай харилцаа, хамтын ажиллагаагаа хөгжүүлэхэд анхаарлаа хандуулахыг зорьж байна. Тэр дундаа Энэтхэг, Хятад хоёр их гүрэн Оросын баруунтай

тасарсан харилцааг нөхөж чадах гол түнш орнууд төдийгүй Оросын төсөөлж буй олон туйлт ертөнцийн гол тэнхлэгийг бүрдүүлж чадах орнууд юм. Үзэл баримтлалд Украины дайнаас үл хамааран Орос, Хятадын харилцаа хэрхэн тууштай хөгжиж байгаад ихээхэн анхаарал хандуулсан. Зарим талаараа, үзэл баримтлалд Хятадыг онцолсон хэдий ч зарчмын, хязгаарлагдмал шинжтэй байгаа нь Орос Улс Латин Америк, Карибын тэнгис, Исламын ертөнц, Африк болон бусад орнуудтай харилцаагаа сайжруулахад илүү их анхаарал хандуулж байгаатай холбоотой бололтой. Энэ өнгө аяс Орос Хятадаас хэт хамааралтай, олон улсын хэмжээнд ганцаардсан гэх барууны үзэл бодлыг үгүйсгэх, дэлхийн олонхи Орос улсыг дэмжиж байна гэсэн Оросын үзэл бодлын илэрхийлэл байж болох юм.

2016 оны үзэл баримтлалд цөмийн зэвсэгтэй гүрнүүдийн хооронд бүх нийтийг хамарсан дайн гарах боломжгүй гэж тэмдэглэж байсан бол шинэ үзэл баримтлалд Орос Улс цөмийн дайн гарах магадлал өндөр байна хэмээгээд цөмийн зэвсэгтэй гүрнүүдийн хооронд мөргөлдөөн үүсэх явдал нэмэгдэж, үүний үр дүнд дэлхийн хэмжээнд дайн гарах магадлал нэмэгдэж байна гэж үзсэн нь түгшүүр төрүүлж байна.

Хуучин ЗХУ-ын үеийн Оросын нөлөөллийн хүрээг сэргээнэ

ЗХУ-ын харьяанд байсан орнуудад нөлөөгөө сэргээх бодлогыг хэрэгжүүлэх үүднээс 1990-ээд оноос хойш хуучин ЗХУ-ын харьяанд байсан орнуудыг “ойрх хилийн чанад” хэмээн нэрлэж байсан нэр томъёог дахин ашиглаж эхэлсэн

нь анхаарал татаж байна. Гэвч энэ нэр томъёо 2000-аад оноос хойш засгийн газрын албан ёсны баримт бичгүүдэд хэрэглэгдэхээ больсон ба учир нь шинээр тусгаар тогносон орнууд тус нэр томъёонд Оросын оройлох, төвт шинж

чанарыг илэрхийлж байсан тул төдийлөн тааламжтай байгаагүйтэй холбоотой юм. Тиймээс Гадаад бодлогын 2013, 2016 оны үзэл баримтлалын хувилбаруудад “ойрх хилийн чанад” гэсэн нэр томъёог Тусгаар улсуудын хамтын нөхөрлөл (ТУХН) гэж нэрлэж байв. Эндээс шинэ үзэл баримтлалд хуучин ЗХУ-ын харьяанд байсан орнуудын талаарх Оросын ойлголт хэрхэн өөрчлөгдсөнийг харуулж байна.

2016 оны үзэл баримтлалд Орос Украинтай харилцах харилцаагаа “ОХУ Украинтай улс төр, эдийн засаг, соёл, оюун санааны харилцаагаа харилцан хүндэтгэх үндсэн дээр хөгжүүлж, үндэсний эрх ашгийг дээдлэн түншлэлийн харилцааг бий болгох сонирхолтой байна” хэмээн тусгасан бол шинэчилсэн үзэл баримтлалд Украин улсын нэр ганцхан удаа дурдагдсаныг тэмдэглэх нь зүйтэй. Гэхдээ энэ нь дээр дурдсанчлан “АНУ болоод Барууны орнуудын хуйвалдааны улмаас Оросыг Украины дайнд татан оруулахад хүргэсэн хэмээн буруутган, Энэ бол ОХУ-ын сонголт биш байсан” хэмээх өгүүлбэрт орсноос өөрөөр дурдагдаагүй байна. 2014 оны 2-р сард Крымын хойгийг Украины нутаг дэвсгэрээс хүчээр нэгтгэж, булаан авсан хэргээр Оросыг Барууны орнууд эдийн засгийн хориг арга хэмжээнд хамруулсан.

2016 оны үзэл баримтлал батлагдах үед Орос Улс Украины зүүн хэсэгт орших Донбасс мужид цэргийн оролцоогоо өргөжүүлж байсны улмаас Украины Засгийн газар төдийгүй Барууны орнуудтай харилцах Оросын харилцаа хурцадмал байдалтай байсан

хэдий ч Орос Улс Украиныг тусгаар улс гэдгийг хүлээн зөвшөөрч байсан нь 2016 оны үзэл баримтлалд тусгалаа олсон байдаг. Гэвч 2023 оны үзэл баримтлалд Украины талаар дээрх байдлаар авч үзсэн нь Оросын Украины талаарх ойлголт, стратеги үндсээрээ өөрчлөгдсөнийг харуулж байна.

Хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаж байсан орнуудаас Оросын эсрэг, Барууны чиг баримжаатай Гүржийн талаарх байр суурь Украины талаарх байр суурьтай адил байна. 2008 оны 8-р сард Өмнөд Осети, Абхазыг Гүржээс салан, тусгаар тогтнох явдлыг эсэргүүцэн өрнөсөн 5 өдрийн Орос-Гүржийн дайны үр дүнд олон улсад хүлээн зөвшөөрөгдөөгүй хэдий ч Өмнөд Осети, Абхаз тусгаар тогтнолоо зарласны улмаас Орос, Гүржийн хооронд дипломат харилцаа тасарсан. 2016 оны гадаад бодлогын үзэл баримтлалд Орос улс Гүржтэй дипломат харилцаагаа хэвийн болгох талаар дурдаж байсан бол 2023 оны үзэл баримтлалд тус асуудал хасагдсан бөгөөд оронд нь Өмнөд Осети, Абхаз хоёртой хамтын ажиллагаагаа нэмэгдүүлэх шаардлагатай талаар оруулсан байна. Түүнчлэн ОХУ-ын Гадаад хэргийн сайд С.Лавров Гүржийн улс төрийн нөхцөл байдал Украиньхтай адил өрнөж байна, Гүрж, Америкийн хуйвалдааны дараа, дараагийн Украин болж байгаад санаа зовж байгаа талаар мэдэгдсэн. Энэ талаар Гүрж, Молдав зэрэг хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан орнуудад Оросын нөлөөллийн хүрээг сэргээхийн тулд Орос цэргийн өдөөн хатгалга явуулж магадгүй гэж Барууны зарим шинжээчид үзэж байна¹⁰.

¹⁰ Davit Gasparyan and Christina Harward. Possible Russian Gains in Georgia and Moldova. <https://www.understandingwar.org/sites/default/files/Possible%20Russian%20Gains%20in%20Georgia%20>

2023 шинэ үзэл баримтлал ба Монгол Улс

ОХУ-ын 2013 оны Гадаад бодлогын үзэл баримтлалд анх удаа Монгол Улстай харилцах харилцааг тодорхойлон “Монгол Улстай уламжлалт нөхөрсөг харилцаагаа бэхжүүлэхийг зорино”¹¹ хэмээн оруулсан ба 2016 оны үзэл баримтлалд¹² тус заалт өөрчлөгдөөгүй боловч Хятад, Энэтхэгийн дараа гурав дахь улс болон шат ахисан явдал Өрнөдийн хоригийн улмаас Ази руу чиглэсэн стратеги бодлого, чиглэлд илүү ач холбогдол өгөх болсонтой холбон үзэж холбох юм.

Харин 2023 оны гадаад бодлогын шинэ үзэл баримтлалд дээрх өгүүлбэр хасагдсан ба үзэл баримтлалын тэргүүлэх чиглэл доторх Еврази тивийн Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улс хэмээн ангиллын хэсэгт Евразийн эдийн засаг, тээврийн харилцан уялдаа холбоог бэхжүүлэх эдийн засгийн коридоруудын нэг болох “Орос-Монгол-Хятад”-ын эдийн засгийн коридорыг байгуулах¹³ талаар дурдснаас өөрөөр Монгол Улсын талаар орсон зүйл заалт алга байна.

Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалд Монгол Улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэл нь ОХУ, БНХАУ-тай бүхэлдээ тэнцвэртэй харилцах, удаах чиглэл нь АНУ, Япон, Европын холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг Өрнө, Дорнын улс, холбоотой “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлнэ¹⁴ хэмээн тусгасан. Гэтэл Монгол Улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэлийн нэг болох ОХУ шууд байдлаар, удаах чиглэлүүд нь дам байдлаар оролцож буй Орос-Украины дайны нөхцөл байдлын үед батлагдсан ОХУ-ын гадаад бодлогын шинэ үзэл баримтлалаас Монгол Улс хасагдсан явдал нээлттэй, олон тулгуурт, энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулах үндсэн зарчмыг баримталдаг Монгол Улсын гадаад бодлого хумигдах, хөрш орнуудын зүгээс ирэх дарамт шахалт нэмэгдэж, олон тулгуурт гадаад бодлогоо хадгалж үлдэхэд сорилт, эрсдэлийг үүсэх магадлалтайг харуулж байна.

[and%20Moldova%20PDF.pdf](#). October 27, 2024,

¹¹ Концепция внешней политики Российской Федерации от 12 февраля 2013 года. // Концепции внешней политики РФ 1993-2023 гг. тексты документов. Б.м.: Б.изд., 2023. IV.86. стр.76 https://library/download/elibrary_50481108_99282815.pdf

¹² Концепция внешней политики Российской Федерации от 30 ноября 2016 года. . Б.м.: Б.изд., 2023. IV.87. стр.95. https://library/download/elibrary_50481108_99282815.pdf

¹³ Концепция внешней политики Российской Федерации (утверждена Президентом Российской Федерации В.В.Путиным 31 марта 2023 г.). // <https://www.mid.ru/ru/detail-material-page/1860586/>

¹⁴ Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал, Монгол Улсын Их хурлын 2011 оны 10 дугаар тогтоолын хавсралт. 14.1, 14.2, // <http://nda.gov.mn/backend/f/2xkJuDjI48.pdf>

Дүгнэлт

ОХУ-ын 2023 оны гадаад бодлогын үзэл баримтлал нь 42 хуудастай бөгөөд дээр дурдсан агуулгаас гадна Оросын гадаад бодлоготой холбоотой бараг бүх асуудлыг цогцоор нь тусгасан болно. ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин шинэ гадаад бодлогын үзэл баримтлалын талаар дүгнэхдээ Орос Улс дэлхийн аль ч улстай дайсагналцдаггүй хэмээн мэдэгдсэн байна. ОХУ Вашингтоны бодлогыг олон улсын энх тайван, аюулгүй байдалд эрсдэл учруулах гол эх үүсвэр гэж үзэж байна, дэлхийн үйл хэрэгт АНУ-ын ноёрхлын ул мөрийг арилгахад нэн тэргүүнд анхаарна, Москва харилцан адил байх зарчмын үндсэн дээр бүх улс орны аюулгүй байдлыг тэгш хангахыг эрмэлзэж байгаагаа илэрхийлсэн.

Түүнчлэн Орос Улс өөрийгөө тусгаарлах бодолгүй байгаа бөгөөд эрх тэгш харилцаа тогтоох эрмэлзэлээрээ дэлхийн бүх улс оронтой хамтран ажиллана гэдэгт найдаж буйгаа онцолжээ.

Украины дайнаар эхэлсэн Барууны эсрэг тэмцэлд Орос Улс Барууны орнуудтай өрсөлдөхөд тийм ч амархан ухрахгүй гэдгийг харуулж байна. Орос Улс ноёрхолоо тогтоох гэсэн Барууны хуйвалдааны эсрэг зөвхөн өөрийгөө хамгаалах үүднээс тэмцэж байгаа тул шударга ёс Оросын талд байж, ялалт гарцаагүй гэсэн үзэл санааг илэрхийлэхийг зорьсон байна. Чингэхдээ 2023 оны үзэл баримтлалаар Оросыг “Барууны дайсан” ч биш, Орос улс Барууны эсрэг дайсагнагч орон ч биш хэмээн үзэж, ингэснээрээ Орос Улс Барууны орнуудад зөвхөн “прагматик

хамтын ажиллагаагаа” сэргээхийг санал болгож байгаа нь харагдаж байна. Гэхдээ прагматик хамтын ажиллагаа гэж яг юуг хэлж байгаагаа тодорхойлоогүй. Украинд үргэлжилж буй дайны эцсийн ялалтад Орос Улс амжилтанд хүрэх эсэхээс үл хамааран Оросын гадаад бодлогын төв тэнхлэг дахин Баруун тийш чиглэх магадлал бага байна. Орос Улс 2023 оны гадаад бодлогын үзэл баримтлалаараа дамжуулан Оросын хэтийн төлөвийг Зүүн, Өмнөд рүү чиглэнэ гэдгээ тодорхой харуулсан.

Орос Улс Баруунтай тасарсан харилцаагаа нөхөхийн тулд Хятад, Энэтхэг төдийгүй дэлхийн өмнөд гэгддэг гуравдагч дэлхийн хөгжиж буй орнуудтай харилцаагаа бэхжүүлэхэд анхаарлаа хандуулах бололтой. Түүгээр ч зогсохгүй Орос Улс Евразийн эдийн засгийн холбоо (ЕАЭБ), Шанхайн хамтын ажиллагааны байгууллага (ШХАБ), БРИКС (Бразил, Орос, Энэтхэг, Хятад, Өмнөд Африк) зэрэг байгууллагуудын хүрээнд хамтын ажиллагаагаа өргөжүүлэх оролдлого хийхээс гадна Оросын статусыг нэмэгдүүлэхийг хичээх төлөвтэй байна. Гэхдээ Оросын олон улсын дэг журам, үндэстний талаарх төсөөлөл биелэх эсэх нь тодорхойгүй байна. Хэдийгээр эрчим хүчний нөөцөөр баялаг орон ч Европ болон Барууны орнууд руу газрын тос, байгалийн хий зэрэг эрчим хүчний нөөцийг экспортлохыг хаасан тул Оросын үндэсний эдийн засагт үзүүлэх дарамт нэмэгджээ.

ОХУ-ын эсрэг хориг арга хэмжээнд оролцоогүй Хятад, Энэтхэг, Турк зэрэг орнууд Оросын эрчим хүчний нөөцийг

хямд үнээр импортолж байсан тул хямралаас зайлсхийж чадсан. Гэвч Орост тавьсан хориг арга хэмжээний үр нөлөөг нэмэгдүүлэх Барууны хүчин чармайлт үргэлжилсээр байгаа бөгөөд Орос Улсын хувьд “эрчим хүчний дайн”-ыг сунжруулах нь тийм ч хялбар биш байх болно. Түүгээр ч зогсохгүй Орос Улс эдийн засгийн хөгжлийн хөдөлгүүрт хохирол учруулахаас зайлсхийх боломжгүйн дээр хориг арга хэмжээнээс үүдэлтэй Барууны томоохон аж ахуйн нэгжүүд Оросыг орхин гарснаас үүдэн бий болсон хамгийн сүүлийн үеийн технологи, эд материалын хомсдол, дутагдал Хятадаас хараат байдлыг нэмэгдүүлж,

В.Путины дотоод хяналтаа чангатгасан дарангуйлал улам хүчтэй болсноор Орос Улс Хойд Солонгостой төстэй болж магадгүй (хойд солонгосчлол) таамаглалд хүргэж болзошгүй байна.

Ийнхүү геополитикийн нөхцөл байдалтай уялдан гарсан ОХУ-ын гадаад бодлогын шинэ үзэл баримтлалын үзэл санаа, чиг хандлага улс орон бүрийн гадаад бодлогод сорилт учруулж буй нөхцөл байдалд Монгол Улс нээлттэй, энхийг эрхэмлэсэн, олонтулгуурт гадаад бодлогоо хадгалан авч үлдэх язгуур ашиг сонирхолоо бүх талаар тууштай баримтлах явдал гадаад бодлогын эн тэргүүний зорилт болж байна.

Ном зүй / References:

1. Конституция Российской Федерации. <http://www.constitution.ru/10003000/10003000-6.htm>. Статья 80-4.
2. Конституция Российской Федерации. <http://www.constitution.ru/10003000/10003000-6.htm>. Статья 84-ё
3. Послание Президента Федеральному Собранию. <http://kremlin.ru/events/president/news/70565>
4. President Bush Visits Bucharest, Romania, Discusses NATO. <https://georgewbush-whitehouse.archives.gov/news/releases/2008/04/20080402-2.html>
5. Путин пригрозил аннексировать Крым и Восточную Украину в случае принятия Украины в НАТО. <https://www.newsru.com/russia/07apr2008/annex.html>. 07.04.2008
6. Основные положения Концепции внешней политики Российской Федерации утверждены Распоряжением Президента Российской Федерации Б.Н.Ельцина от 23 апреля 1993 г. // Концепции внешней политики РФ 1993-2023 гг. тексты документов. Б.м.: Б.изд., 2023. стр.6 https://library/download/elibrary_50481108_99282815.pdf,
7. Концепция внешней политики Российской Федерации от 28 июня 2000 года. // Концепции Внешней политики РФ. 1993-2023 гг. тексты документов. Б.м.: Б.изд., 2023. стр.34. https://library/download/elibrary_50481108_99282815.pdf,
8. Концепция внешней политики Российской Федерации от 31 марта 2023 года. // Концепции внешней политики РФ 1993-2023 гг. тексты документов. Б.м.: Б.изд., 2023. стр.98 https://library/download/elibrary_50481108_99282815.pdf,
9. Davit Gasparyan and Christina Harward. Possible Russian Gains in Georgia and Moldova. // <https://www.understandingwar.org/sites/default/files/Possible%20Russian%20Gains%20in%20Georgia%20and%20Moldova%20PDF.pdf>. October 27, 2024
10. Концепция внешней политики Российской Федерации от 12 февраля 2013 года. // Концепции внешней политики РФ 1993-2023 гг. тексты документов. Б.м.: Б.изд., 2023. IV.86. стр.76 https://library/download/elibrary_50481108_99282815.pdf,
11. Концепция внешней политики Российской Федерации от 30 ноября 2016 года. Б.м.: Б.изд., 2023. IV.87. стр.95. https://library/download/elibrary_50481108_99282815.pdf
12. Концепция внешней политики Российской Федерации (утверждена Президентом Российской Федерации В.В.Путиным 31 марта 2023 г.). // <https://www.mid.ru/ru/detail-material-page/1860586/>
13. Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал, Монгол Улсын Их хурлын 2011 оны 10 дугаар тогтоолын хавсралт. 14.1, 14.2, // <http://nda.gov.mn/backend/f/2xkJuDjl48.pdf>

An Analysis of the 2023 New Foreign Policy Concept of the Russian Federation

Nyamdoljin Adiya

Ph.D

Institute of International Studies,

Mongolian Academy of Sciences, Ulaanbaatar, Mongolia

nyamdoljin@mas.ac.mn

Abstract: *The article aims to compare the features of the new Foreign Policy Concept of Russia adopted in 2023 with the previous concepts of 1993, 2000, 2008, 2013, and 2016, and to study the newly proposed ideas, concepts, and trends in the context of the Russia-Ukraine war. In addition, when considering the policy pursued by Russia towards Mongolia to the provisions of the new concept, there is an urgent need to anticipate and analyze the challenges facing Russia-Mongolia relations, which is one of the priorities of Mongolia's foreign policy.*

Keywords: *Russia, foreign policy concept for 2023, Russia-Ukraine, geopolitics*

The day of submission: 2024.10.09

Completion of Review: 2024.11.19

Final Decision for Acceptance: 2024.12.25